



МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ САЛБАРТ ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

2024 оны 8 дугаар сар

Агуулга

| | |
|--|----|
| 1. Ерөнхий мэдээлэл..... | 3 |
| Тулгарч буй асуудал | 3 |
| Зөвлөмж | 3 |
| 2. Замын зураг | 5 |
| АЛХАМ 1. Манлайлал, үүрэг амлалтыг сэргээх..... | 6 |
| АЛХАМ 2. Хууль эрх зүйн хүрээг бэхжүүлэх..... | 7 |
| АЛХАМ 3. ОУИТБС-ын тухай хуулийг батлах..... | 7 |
| АЛХАМ 4. Гэрээний мэдээллийн санг сайжруулах..... | 8 |
| АЛХАМ 5. Сайн дураар тайлагнахыг дэмжих нь | 9 |
| АЛХАМ 6. Иргэний нийгмийн оролцоог бэхжүүлэх нь | 10 |
| АЛХАМ 7. Чадавхийг бэхжүүлэхэд хөрөнгө оруулах | 10 |
| АЛХАМ 8. Байгаль орчны баримт бичгийн нээлттэй байдлыг сайжруулах нь | 11 |
| АЛХАМ 9. Тодорхой удирдамж боловсруулах нь | 11 |

Нүүр хуудасны зураг: Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн

1. Ерөнхий мэдээлэл

Энэ тайланд Монгол Улсын олборлох салбарт мөрддөг гэрээний ил тод байдлыг сайжруулах төлөвлөгөө буюу замын зураглалын хувилбарыг танилцуулж байна. Уг замын зураглалыг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэг, санхүүжилтээр Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгээс гүйцэтгэсэн гэрээний ил тод байдлын нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны үр дүн, зөвлөмжид үндэслэн боловсруулсан болно.

Тулгарч буй асуудал

- **Гэрээний жагсаалт бүрэн бус:** Олборлох салбарт олон хэлбэрийн гэрээ байгуулдаг ч тэдгээрийн бүрэн жагсаалт байхгүй байгаа нь ил тод байдал болон эгэх хариуцлагад сөргөөр нөлөөлж байна.
- **Ил тод нийтлэх шаардлага хязгаарлагдмал:** Өнөөгийн хууль тогтоомж нь зөвхөн тодорхой тооны гэрээг ил тод нийтлэхийг шаарддаг нь ОУИТБС-ын стандарт болон олон нийтийн хүлээлтэд хүрэхгүй байна.
- **ОУИТБС-ын тайлангууд хангалтгүй:** Монголын ОУИТБС-ын тайлангууд нь ил тод нийтлэх шаардлагуудыг бүрэн биелүүлэх түвшинд хүрээгүй байна.
- **Бодлогын үүрэг амлалт биелэхгүй байна:** ОУИТБС-ын тухай хууль батлах гэх мэт гэрээний ил тод байдлыг дээшлүүлэх хэд хэдэн санаачилга байдаг ч тэдгээрийн ихэнх нь ажил хэрэг болж чадахгүй байна.

Зөвлөмж

- **Манлайлал, үүрэг амлалтыг сэргээх:** Засгийн газар болон Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээний ил тод байдлыг сайжруулах үүрэг амлалтыг сэргээн тодотгох шаардлагатай. Оролцогчдын бүлэг өмнөх алдаа дутагдлыг тодорхойлж, гэрээний ил тод байдлыг шинэ шатанд шуурхай гаргаж чадах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэргээр яриа, хэлэлцүүлгийг манлайлбал зохино.
- **Хууль эрх зүйн хамрах хүрээг тэлэх:** Төр засгийн зүгээс гэрээ хэлэлцээрийг зохицуулдаг хууль тогтоомжийг шинэчилж, хөрөнгө оруулалтын, бүтээгдэхүүн хуваах,

Монгол Улсын гэрээний ил тод байдлыг сайжруулах замын зураглал

орд ашиглах зэрэг олборлох салбарын бүх чухал гэрээг ил тод нийтлэхийг шаардвал зохино.

- **ОУИТБС-ын тухай хуулийг нэн тэргүүнд тавих:** ОУИТБС-ын тухай хуулийг батлах нь гэрээний ил тод байдлыг өргөн хүрээнд хангахад чухал үүрэгтэй. Засгийн газар энэ хуулийг батлуулахыг чухалчлах, эсхүл одоо мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах гэх мэт ил тод байдлыг сайжруулахад ижил нөлөө үзүүлэхүйц тодорхой хувилбаруудыг санал болгох шаардлагатай.
- **Хэрэгжилтийг сайжруулах:** Засгийн газар нь Гэрээний мэдээллийн санд гэрээг бүрэн бөгөөд алдаа мадаггүй нийтлэх шаардлагатай байна. Үүнд нээлттэй нийтэлсэн гэрээг харьцуулан шалгах, гэрээг баталгаажуулах журмыг боловсруулах зэрэг ажил орно. ОУИТБС-ийн нэгтгэл тайлангийн хүрээнд гэрээг бүрэн хэмжээнд, цаг тухайд нь нийтэлж буй эсэхийг үнэлэх ёстой.
- **Сайн дураар тайлагнахыг дэмжих:** Засгийн газар нь хуулийн шаардлагыг биелүүлэхээс гадна өргөн хүрээний гэрээг сайн дураараа, ил тод нийтэлдэг компаниудыг урамшуулах нь зүйтэй.
- **Иргэний нийгмийн оролцоог бэхжүүлэх:** Иргэний нийгмийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллах нь нэн чухал. Засгийн газар тэдний санал, шүүмжийг сонсож, ил тод байдлыг сайжруулахад хамтран ажиллахын сацуу бүх оролцогч талуудыг хариуцлагажуулахад анхаарах хэрэгтэй.
- **Чадавхыг бэхжүүлэхэд анхааран ажиллах:** Оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх замаар гэрээний ил тод байдлын шаардлагыг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх нь зүйтэй. Сургалтын хөтөлбөр нь гэрээг хянах, дүн шинжилгээ хийх, ил тод нийтлэх, мониторинг хийх зэрэг сэдвийг хамарвал зохино.
- **Байгаль орчны баримт бичгийн ил тод байдлыг сайжруулах:** Засгийн газар хууль тогтоомжийн дагуу шаарддаг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан зэрэг байгаль орчинтой холбоотой баримт бичгийн олон нийтэд нээлттэй байдлыг баталгаажуулах ёстой.
- **Тодорхой удирдамж боловсруулах:** ОУИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээг ил тод нийтлэх тодорхой удирдамж, стандартыг боловсруулах нь зүйтэй.

Дүгнэхэд, Монгол Улс олборлох салбарын гэрээний ил тод байдлыг сайжруулах талаар олон ажил санаачилж ирсэн ч бэрхшээл, сорилтууд байсаар байна. Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх

нь гэрээний ил тод байдлыг өргөн хүрээнд сайжруулах, ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангах, олон нийтийн ойлголт, хариуцлагыг төлөвшүүлэхэд нэн чухал юм.

2. Замын зураг

Энэ хэсэгт Засгийн газар болон Олон талт оролцогчдын бүлэг хамтарч Монгол Улсын олборлох салбарын гэрээний ил тод байдлыг сайжруулахын тулд хэрэгжүүлэх ажил, замын зураглалыг тайлбарлаж байна.



АЛХАМ 1. Манлайлал, үүрэг амлалтыг сэргээх

Засгийн газар болон Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээний ил тод байдлыг сайжруулахад илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Ялангуяа ОУИТБС-ын стандартын Шаардлага 2.4.b-ын дагуу Оролцогч талуудын бүлэг нь гэрээг ил тод нийтлэхэд тулгарч буй саадыг арилгах, хэрэгжүүлэх ажлын тодорхой хугацаа заасан төлөвлөгөө боловсруулах, нийтлэхийг зөвлөсөн байдаг.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь өмнө нь гүйцэтгэсэн ажлаа дүгнэх, гэрээний ил тод байдлыг сайжруулах зорилготой тодорхой төлөвлөгөө боловсруулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх гэрээний жагсаалтыг гаргах чиглэлээр засгийн газрын байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг сэдвээр цуврал дугуй ширээний ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах. Уг үйл ажиллагааны төлөвлөгөөг Монголын ОУИТБС болон Ажлын хэсэг жилийн ажлын төлөвлөгөөндөө бүрэн тусгах хэрэгтэй.
- Олон талт оролцогчдын бүлэг нь засгийн газрыг гэрээний ил тод байдлыг сайжруулах талаар авсан үүрэг амлалтаа бататгахыг уриалах, улмаар засгийн газрын манлайллыг шинээр баталгаажуулах.
- Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээний ил тод байдлын асуудлаар дэд ажлын хэсэг байгуулах, бүрэлдэхүүнд нь Сангийн яам, Хууль зүйн яам, Аж үйлдвэр, уул уурхайн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, олборлох салбарын компани болон иргэний нийгмийн төлөөллийг оруулах.
- Дэд ажлын хэсэг нь хүчин төгөлдөр мөрдөж буй бүх тусгай зөвшөөрөл, гэрээний бүрэн жагсаалтыг боловсруулах. Уг жагсаалтад хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээ бүрийг нийтэлсэн, нийтлээгүй гэсэн төлөвөөр ангилах, нийтэлсэн гэрээ бүрийн зөв холбоосыг мөн жагсаалтад оруулах.
- Олон талт оролцогчдын бүлэг нь засгийн газрын агентлагтай хамтрах замаар бүтээгдэхүүн хуваах гэрээний бүрэн эх хувилбарыг нийтлэх боломжийг эрэлхийлэх.
- Олон талт оролцогчдын бүлэг нь одоогийн байдлаар төрийн бус байгууллагын хариуцаж буй Гэрээний порталын хариуцагчийг тодорхой болгох.

АЛХАМ 2. Хууль эрх зүйн хүрээг бэхжүүлэх

Төр засаг олборлох салбарын хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүн хуваах, орд ашиглах зэрэг бүх чухал гэрээг ил тод нийтлэх шаардлагыг тусгасан зохицуулалт, хууль тогтоомжийг бүрдүүлэх шаардлагатай.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь засгийн газартай хамтарч дараах ажлыг гүйцэтгэх замаар гэрээг нийтлэх шаардлагыг хууль тогтоомжид тусгах. Үүнд:
 - Олборлох салбарын гэрээг ил тод нийтлэх шаардлагыг хууль тогтоомжид тусгахын тулд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль эсвэл Ашигт малтмалын тухай хуулийн төсөл зэрэг холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг засгийн газар тэргүүн ээлжид анхаарахыг онцлох.
 - Тодорхой бөгөөд иж бүрэн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулахад Олон талт оролцогчдын бүлгийн мэргэжлийн ур чадвар болон салбарын холбоо сүлжээг ашиглахыг санал болгох.
- Олон талт оролцогчдын бүлэг нь дараах байдлаар хэрэгжилтийг хангах үр дүнтэй арга хэрэгслийг санал болгох:
 - Гэрээний ил тод байдлыг хангах ажлыг хэрэгжүүлэх тодорхой журам боловсруулах талаар засгийн газар анхаарахыг онцлох.
 - Гэрээ хүчин төгөлдөр болох эсхүл олон нийтэд нээлттэй байх нөхцөл нь мэдээллийн санд гэрээг нийтлэх явдал байхыг шаардах зэрэг хэрэгжилтийн үр дүнтэй арга хэрэгслийг засгийн газар бий болгох явдлыг дэмжих.
 - Шинээр байгуулсан гэрээ, хүчин төгөлдөр мөрдөж буй гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хянах, эдгээрийг ОУИТБС-ын тайланд бүрэн тусгах ажлыг ОУИТБС-ын Ажлын алба ба ашигт малтмалын асуудал эрхэлсэн яаманд хариуцуулах.

АЛХАМ 3. ОУИТБС-ын тухай хуулийг батлах

Засгийн газар нь гэрээний ил тод байдлыг өргөн хүрээнд хангах зорилгоор ОУИТБС-ын бие даасан хуулийг батлах ажлыг чухалчлах нь зүйтэй.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь энэ хуулийг батлах ажлыг нэн тэргүүний ажил болгохыг засгийн газар анхаарах ёстойг онцлох.
- Олон талт оролцогчдын бүлэг нь иргэний нийгмийн байгууллага, салбарын холбоодтой хамтарч ОУИТБС-ын тухай хуулийн төслийн дэмжлэгийг олох зорилгоор энэ хуулийн үзүүлэх нөлөө, тэр дундаа гэрээний ил тод байдлыг сайжруулах ач холбогдлын талаар олон нийтийн ойлголтыг сайжруулах кампанит ажлыг эхлүүлэх.
- Олон талт оролцогчдын бүлэг нь дээрх арга хэмжээтэй зэрэгцүүлэн ОУИТБС-ын хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж, уг хууль нь гэрээний ил тод байдлыг сайжруулах чиглэлд ахиц гаргах явдлыг баталгаажуулахын тулд засгийн газарт бүтээлч саналаа хүргүүлэх.
- Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС-ын хуулийг батлах ажил удааширсан тохиолдолд авах арга хэмжээг давхар төлөвлөж, хуулийн төслөөр зорьсонтой адил хэмжээний үр дүнг авчрах хувилбарын саналыг боловсруулах. Үүнд гэрээний ил тод байдлын хамрах цар хүрээг өргөжүүлэхийн тулд одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, тухайлбал Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах зэрэг ажлыг хамруулж болно.

АЛХАМ 4. Гэрээний мэдээллийн санг сайжруулах

Засгийн газар нь Гэрээний мэдээллийн сангийн нийтэд хүртээмжтэй байдал болон ашиглах боломжийг сайжруулах хэрэгтэй. Үүнд бүрэн болон бодит гэрээ, гэрээний нэмэлт өөрчлөлтийг порталд нийтлэхээс гадна засгийн газрын байгууллага хооронд мэдээлэл солилцох замаар гэрээ, нэмэлт өөрчлөлтийг нягтлан хянах, ОУИТБС-ын хүрээнд гэрээг албан ёсоор баталгаажуулах зэргийг нэвтрүүлэх боломжтой. Ялангуяа ОУИТБС-ын нэгтгэл тайланд гэрээ нийтлэх ажлыг дүгнэхдээ гэрээний иж бүрэн хувилбарыг хугацаанд нь нийтэлсэн байх шалгуурыг баримтлах нь зүйтэй.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь Гэрээний мэдээллийн санг цаашид удирдах, хариуцах талаар засгийн газар, түүнчлэн иргэний нийгэм, салбарын төлөөлөлтэй хэлэлцэх шаардлагатай. Үүний зорилго нь зохих нөөц боломжтой этгээд буюу

жишээлбэл, засгийн газрын байгууллага эсвэл ОУИТБС-ын Ажлын алба уг мэдээллийн санг хариуцан ажиллах явдал юм. Тухайн байгууллага нь порталыг хариуцсан ажилтан, мэдээлэл цуглуулах, цэгцлэх, шинэчлэх төсөв зэрэг нөөц боломжтой байх ёстой. Түүнчлэн, порталын программ хангамж, системийн шинэчлэлийг хариуцна.

- Гэрээний порталын эзэмшлийг тодорхой болгосны дараа олон талт оролцогчдын бүлэг нь порталын администратортай хамтрах замаар нийтэлсэн гэрээг засгийн газрын агентлагуудын тайлагнасан гэрээтэй харьцуулан шалгах зэргээр мэдээллийн чанарыг хянах далайцтай арга хэмжээг хэрэгжүүлбэл зохино.
- Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС-ын нэгтгэл тайланг бэлдэх багтай хамтарч гэрээг бүрэн хэмжээнд буюу нэмэлт өөрчлөлтийг хамруулан нийтэлсэн эсэхийг үнэлэхийн тулд дараах ажлыг гүйцэтгэх хэрэгтэй. Үүнд:
 - Порталд нийтэлсэн гэрээ нь иж бүрэн, ойлгомжтой, хугацаандаа хэвлэгдсэн зэрэг тодорхой үзүүлэлтийг ашигласан гэрээний үнэлгээг ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн хүрээнд гүйцэтгэх.
 - ОУИТБС-ын нэгтгэгч нартай хамтран нийтэлсэн гэрээнд ямар нэгэн орхигдсон гэрээ, эсхүл зөрүүтэй байдал байгаа эсэхийг тодорхойлж, засаж залруулах арга хэмжээ авах.

АЛХАМ 5. Сайн дураар тайлагнахыг дэмжих

Засгийн газар нь гэрээг хуулиар хүлээсэн үүргээс гадна буюу сайн дураараа, ил тод нийтэлдэг компаниудыг дэмжиж ажиллах нь зүйтэй.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь салбарын холбоодтой хамтрах замаар тэдний гишүүн компаниудыг гэрээг сайн дураар нийтлэхийг дэмжих. Үүнд гэрээг сайн дураар нийтлэхийн ашиг тус, гэрээг нийтлэх үр дүнтэй арга зам зэрэг сэдвээр компаниудад зориулсан семинар, сургалт зохион байгуулах.

АЛХАМ 6. Иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх

Засгийн газар нь гэрээний ил тод байдлыг сайжруулах ажлын хүрээнд иргэний нийгмийн саналыг сонсох, тэдэнтэй хамтран ажиллах талаар идэвхтэй ажиллах шаардлагатай.

АРГА ХЭМЖЭЭ:

- Засгийн газар нь гэрээний ил тод байдлын талаар хийж буй ажил, санаачилгын талаар иргэний нийгэмтэй санал, мэдээлэл солилцох тогтмол хэлэлцүүлгийг зохион байгуулах.
- Засгийн газар гэрээний ил тод байдалтай холбоотой хуулийн төсөл, бодлого, дүрэм журмын талаар иргэний нийгмийн санал, бодлыг авах талаар идэвх гарган ажилладаг байх.

АЛХАМ 7. Чадавхыг бэхжүүлэхэд анхааран ажиллах

Олон талт оролцогчдын бүлэг нь сургалтын хөтөлбөрийг аймаг болон сумын засаг захиргаа, орон нутгийн иргэний нийгмийн төлөөлөлд хүргэх замаар оролцогчдын хүрээг тэлэх. Эдгээр сургалт нь хүчин төгөлдөр мөрдөж буй гэрээний бүрэн хувилбарыг нийтлэх (үүнд гэрээний орчуулга, мета буюу ерөнхий мэдээллийг агуулсан өгөгдөл), гэрээг нийтлэх шаардлага, мониторингийн хэрэгсэл зэрэг гэрээг нийтлэхтэй холбоотой ОУИТБС-ын ба хууль тогтоомж дахь шаардлагыг хамарсан байвал зохино.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь засгийн газрын холбогдох агентлаг, компани, иргэний нийгмийн байгууллагатай хамтарч, олборлох салбарын гэрээний ил тод байдлын талаар сургалтын цогц хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх. Хөтөлбөр дараах сэдвийг хамарч болно:
 - Хүчин төгөлдөр мөрдөж буй гэрээний бүрэн хувилбарыг нийтлэх ОУИТБС болон хууль эрх зүйн шаардлага.
 - Янз бүрийн салбар, мэргэжлийн оролцогч талууд гэрээний үүрэг, түүний биелэлтэд хийх дүн шинжилгээ болон мониторинг.
 - Олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компанид тавигддаг мэдээллийг нийтлэх шаардлага.

- Мэдээллийг нийтлэх шаардлагыг мөрдөж буй эсэхийг хянах мониторингийн хэрэгсэл.
- Мэдээлэл хүргүүлэх болон авах зэрэгтэй холбоотой гэрээний порталын үр дүнтэй ашиглалт.

АЛХАМ 8. Байгаль орчны баримт бичгийн ил тод байдлыг сайжруулах

Засгийн газар нь хууль тогтоомжийн дагуу шаарддаг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, тайлан зэрэг байгаль орчинтой холбоотой баримт бичгийн олон нийтэд нээлттэй байдлыг ханган ажиллах ёстой.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтрах замаар байгаль орчны мэдээллийн санг үнэлэх, түүнчлэн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, тайлан зэрэг хуулиар шаарддаг, байгаль орчны холбогдолтой баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгох бодлогыг боловсруулах.

АЛХАМ 9. Тодорхой удирдамж боловсруулах

ОУИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээг ил тод нийтлэх тодорхой удирдамж, стандартыг боловсруулах нь зүйтэй.

АРГА ХЭМЖЭЭ:

- Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээг ил тод нийтлэх шалгуурыг боловсруулах. Үүнд ил нийтлэх гэрээний төрөл, агуулсан байвал зохих мэдээлэл, нийтлэх хугацаа болон хэлбэр зэрэг нарийвчилсан мэдээллийг тодорхойлох.